



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 05 одөр

Дугаар 73

Эрдэнэт

“Хүүхдийн номын ордон”-г
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Аймгийн “Хүүхдийн номын ордон”-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн байгуулсугай.

Хоёр: Аймгийн Засаг дарга Д.Батлутад ДААЛГАХ нь:

2.1.Хүүхдийн номын ордон байгуулахтай холбогдуулан үйл ажиллагаагаа явуулах байрны асуудлыг шийдвэрлэх.

2.2.Хүүхдийн номын ордны үйл ажиллагаа явуулах төсвийг 2018 оны улсын төсөвт суулгах асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд тавьж шийдвэрлүүлэх.

ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА

